

ӨВӨР МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙН ТОЙМ**Ц. Баатар**

Өвөр Монголын өөртөө засах орны (ӨМӨЗО) бэлчээрийн талбай нь БНХАУ-ын бүх бэлчээрийн гуравны нэг хувийг эзлэдэг юм.¹

Бэлчээрийн мал аж ахуй нь Өвөр Монголд өнө эртний уламжлалтай салбар билээ. Тийм ч учраас тухайн үедээ Өвөр Монголын эдийн засгийн тулгуур салбар нь болж байсан мал аж ахуй одоо өөртөө засах орны хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гуравны нэг хувийг гаргаж байна.²

1986 оны байдлаар ӨМӨЗО-ы мал аж ахуй эрхэлж буй 32 хошуунд бог, бод нийлсэн 30 сая мал байгаа ажээ.³ Нийт малын 56-58 хувь нь Ордосын өндөрлөгийн хойд болон баруун хэсэгт тухайлбал, Хөлөн буйр, Шилийн гол, Улаан цав, -Баян нуур, Алшаа, Ордосын мал аж ахуй дагнан эрхэлж буй бүс нутагт; 42-44 хувь нь газар тариалан эрхэлсэн Хянганы аймаг, Хөлөн буйр аймгийн Нун мөрний сав газар, Их Хянганы хотгор, Жирэм, Зуу-Уд аймгийн нутаг, Баяннуур аймгийн Ордосын нутаг, Их зуу аймгийн гол мөрний эрэг орчмын нутаг, Мөн Улаан цав аймгийн гол устай элсэрхэг нутаг, ойн аж ахуй мал аж ахуй хослон эрхэлдэг Их Хянганы нурууны ойн бүс, Хэлэнь, Данинь, Майхан уулын бүс нутаг, Шар мөрний дунд хавийн 8 хошуу, газар тариалан мал аж ахуй хосолсон Их Хянганы нуруу, Түмэдийн тал, баруун Ляо голын сав газар, Зуу-Уд аймгийн өмнөд хэсэг, Нун мөрний баруун эрэг орчмын нутагт тус тус байршжээ. Бэлчээрийн ихэнх нь тус өөртөө засах орны нутаг дэвсгэрийн гуравны хоёрыг эзлэх хил орчмын өндөр уул, тал хээр, ойт хээр, говийн бүс нутаг юм. Мал сүргийн байршил нь байгаль цаг уурын нөхцөл, бүс нутгийн онцлогтой уялдаж янз бүр байна. Тухайлбал, Хөлөнбуйр, Жирэм, Зуу-Уд, Шилийн голын аймагт адуу, үхэр, нарийн ноост хонь өсгөхөд тохиромжтой бүс нутаг юм. Улаан цав аймгийн хойд хэсэг Баян-нуур. Их зуу, Алшаа аймаг тэмээ, ямаа, хонь өсгөхөд илүү тохиромжтой бүс нутаг ажээ.

Мал аж ахуй эрхэлж буй нутагт 1,7 сая хүн амтай 332 мянга орчим өрх оршин сууна. Түүний 90 хувь нь Өвөр Монголын уугуул хүн ам болох монголчууд байна. Арав орчим хувь нь манж, дагуур, орчоон, эвенк, солонгос, төвд зэрэг цөөн тоот үндэстэн байх бөгөөд тэд ойн аж ахуй, мал аж ахуй хослон эрхэлдэг бүс нутагт оршин сууна. Мал аж ахуй эрхэлж буй нутагт биеийн хүчин үнэлж, мал маллаж байгаа хүн нийтдээ 545 мянга орчим байгаа ажээ⁴.

ӨМӨЗО байгуулагдсанаас хойших 40 жилийн хугацаанд Хятадын коммунист намаас (ХКН) мал аж ахуйн талаар явуулсан бодлогын дотроос хоёр зурвас үеийг малчид нэлээд нааштайгаар үзэж байна. Нэгдэх үе нь өөртөө засах орон байгуулагдсаны эхний 10 жил, хоёр дахь үед ХКН-ын XI удаагийн Төв Хорооны III бүгд хурлаас (1978) хойших хугацаа орж байна. Эхний 10 жилд феодал, сүм хийдийн малыг хурааж, ядуу ардын аж амьдралыг дээшлүүлэх, мал аж ахуйг

1 «Монголын судлал» сэтгүүл (Япон хэлээр) Осака, 1984 № 7. 57-р тал

2 Нэй Мэнгу нүне дили. Хөх хот, 1982, 151-р тал

3 «Жэньминь жибао» 1986. 2.19.

хөгжүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх, малчдын хувийн аж ахуйг хөгжүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлэх чиг бодлого явуулав. Энэ нь зохих үр дүнд хүрч малчин монголчуудын мал сүргээ өсгөн арвижуулах урам зоригийг нь сэргээж тэдний аж байдал ч мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан үе байлаа. 1957 он гэхэд малчдын амины мал 36 болж өрхийн жилийн дундаж орлого 1200 юаньд хүрсэн байв⁵. Гэтэл Хятадын коммунист намын улс төрийн чиг бодлого өөрчлөгдөж энэ үеийн ардчилсан зарим өөрчлөлтийг буруушааж, 1958 онд өвөр монголын мал бэлчээрийг нийт үндэстний өмч болгон малчдыг нийтээр нь коммунд хүчээр оруулав. Энэ нутгийн уугуул оршин суугчид болох монголчуудыг дотогш нь нүүлгэж⁶ хятад тариачдыг асар их хэмжээгээр энэ нутагт суурьшуулж бэлчээр хагалж газар тариалан эрхлэхийг тэдэнд зөвшөөрсөн байна.

Үндэсний асуудал, мал аж ахуйн салбарын онцлогийг үл харгалзан түүнийг аж ахуйн хоёр дахь салбар хэмээн үзэж Хятадын газар тариалангийн районд явуулсан бодлогыг тэр хэвээр нь хэрэглэсэн явдал Өвөр Монголд эдийн засгийн тэнцвэр алдагдаж, мал аж ахуйн хөгжил зогсонги байдалд орж ард олны амьдрал ч доройтсон байна.

Өвөр Монголд хятад иргэд бөөнөөр ирж суурьших болсноор хүн амын механик өсөлт хэт ихэссэн нь бэлчээрийг хагалах явдлыг хязгааргүй нэмэгдүүлэв. Тухайлбал одоо ашиглаж байгаа бэлчээрийн талбай 1947 оныхоос 6 сая га-гаар хорогджээ.⁷ Мөн хугацаанд 800 сая му (1 му 0,06 га-тай тэнцэнэ) нутаг бэлчээр элсэнд автсан байна.⁸ Бэлчээр тэжээлийн нөөцийг 50-иад оныхтой харьцуулахад 30—50 хувь буурч зарим газар 60 хувиас давсан байлаа.

Үүнээс болж бэлчээрийн талбай хумигдаж мал өсгөх боломж ч хязгаарлагдмал болж «бэлчээр-мал-ажиллах хүчний» зохистой харьцаа алдагдсан байна.⁹

Энэ үед малын тоо толгой нэмэгдсэнгүй, судалгаанаас үзэхэд Өвөр Монголын малын өсөлт 1947—1953 онд дунджаар 8,5 хувь байсан бол 1954—1968 онд 3,1 хувь болж, 1969—1978 онд малын тоо толгой өссөнгүй харин хорогджээ.

Малын тоо толгой цөөрхөд нөлөөлсөн олон хүчин зүйлийн нэлээд хувийг нь бэлчээрийн талбай асар их хэмжээгээр багассан явдалтай холбон үзэж болох юм. Бэлчээрийн нөхцөлд мал өсгөх боломжийн талаар хятадын хэвлэлд янз бүрээр бичиж байна. «Өвөр Монголын хөдөө аж ахуйн газар зүй» номд бичсэнээр бол ашиглаж болох талбай 66,6 сая га, бэлчээр тэжээлийн нөөц нь 133,6 сая тонн бөгөөд бог малд шилжүүлснээр 33,4 сая малд хүрэлцэнэ гэж тооцсон байна.¹⁰ Дээрх бэлчээрээс өвөл, хаврын улирлын 53,2 сая га бэлчээрийн тэжээлийн нөөц нь 39,6 сая тн, нэг хонь өдөрт 5 кг өвс иднэ гэж үзвэл бэлчээрийн талбай нь 23,6 сая малд хүрэлцэх ажээ. Үүнийг 1986 онд байгаа 30 сая малын тоотой харьцуулахад даруй 7 сая гаруй мал бэлчээрийн даацнаас илүү байна. Ер нь 1980 оноос Өвөр Монголын бэл-

4 Нэй мэнгү нун е дили. Хөх хот, 1982. 151-р тал

5 Өвөр Монголын өөртөө засах орны аж ахуйн хөгжлийн тойм. (П боть) Хөх хот, 1983, 460-р тал

6 «Үйлдлэг» 1985, No 2, 8-р тал

7 «Монголын судлал» сэтгүүл (япон хэлээр), Осака, 1984. No 7. 64-р тал

8 «Хунци» 1984, No 6, 22-р тал

9 «Монголын судлал» сэтгүүл (Япон хэлээр), Осака, 1984, No 7. 66-р тал.

Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан» сэтгүүл, 1986, N 2.

10 Нэй мэнгү Нун е дили Хөх хот, 1982. 155-р тал

чээрийн талбай эрс багасч мал бэлчээрийн даацнаас их байгаа талаар Хятадын хэвлэлд өргөн шүүмжлэл явагдаж, эцсийн дүнд малыг их хэмжээгээр цөөрүүлж эхэлсэн билээ. Үүний нэг тодорхой жишээ бол 1980 онд байсан 40,6 сая малаа зургаахан жилийн дотор 10,6 саяар цөөрүүлэв.

Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ улсын хэмжээгээр улам бүр ихэсч энэ асуудал шийдвэрлэвэл зохих эдийн засгийн зангилгаа асуудлын нэг болжээ. Гэвч бэлчээрийн талбай, тэжээлийн нөөц хүрэлцээгүй учраас арга буюу мал сүргийн өсөлтийн хэмжээг хязгаарлахад хүрч, тухайн жилд бойжуулсан төлийн тоог харгалзан тэр хэмжээгээр, түүнээс ч илүү тоогоор малыг бөөнөөр нь дотоод гадаадын зах зээл дээр гаргаж худалдан борлуулах ажлыг эрчимтэй явуулах болов. Энэ чиглэлээр капиталист орнуудтай хамтран ажиллаж, мал бордож борлуулахад чиглэсэн томоохон цогцолборууд байгуулж байна. Тухайлбал, махны үхэр бордож гадаадад гаргах Хятад - Америкийн хувь нийлүүлсэн цогцолбор 1986—1990 онд жил бүр махны 50 мян, үхэр 1992—1998 онд жил бүр 100 мянган үхрийг тус тус худалдан борлуулах төслийн хүчин чадалтай юм. Түүнчлэн ойрын 3-5 жилд нэг сая хонийг гадаадын зах зээл дээр гаргаж худалдахаар төлөвлөжээ.¹¹

1985 оны 4 дүгээр сарын 23-нд хуралдсан ӨМӨЗО-ы Ардын төлөөлөгчдийн хурлын 6 дахь удаагийн сонгуулийн гуравдугаар чуулган дээр ӨМӨЗО-ы Ардын засгийн дарга Бөхөө бэлчээрийн даацнаас хэтэрсэн «малыг худалдан цөөрүүлж (дотоод, гадаад зах зээлд -Ц.Б) байгаа нь сайн хэрэг боловч 1984 онд дэндүү олон мал худалдлаа. Хээлтэгч мал худалдах явдлыг зогсоож, хяналт тавих хэрэгтэй. 3-5 жилийн дараа мал худалдах явдалд өөрчлөлт гарга»¹² гэж мэдэгдсэнээс үзэхэд мал, бэлчээрийн зохистой харьцаа өнөө хир бүрдээгүй учраас одоо байгаа малын тоо толгой өсөх биш харин цөөрөх төлөвтэй байна.

1958 оноос хойш мал аж ахуйг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах талаар системтэй арга хэмжээ аваагүй учраас мал аж ахуйн үржил селекцийн ажил бараг зогссон байна. «Гурван гол»-ын үүлдэрийн үхэр, адуу Өвөр Монголын нарийн ноост хонь, үзэмчин хонь, Алшаа тэмээ зэрэг нутгийн шилмэл үүлдэрийн мал нийт сүргийн дотор эзлэх хувь эрс буурчээ. Үүнээс болж малын яс, чанар, ашиг шим зарим талаар буурч мал аж ахуйн салбарын бүтцэд ч муу нөлөө үзүүлжээ. Ялангуяа мал сүргийн дотор хамгийн таваарлаг нь болох бод малын эзлэх хувь багассан байна. 1949 онд мал аж ахуйн салбарын бүтцэд бод 32 хувийг эзэлж байсан бол 1979 онд дөнгөж 18,6 хувийг эзэлж байв.¹³ Өнөөгийн байдлаар нийт мал сүргийн дотор хээлтэгч 30-35 хувийг эзлэж байна. Төл бойжуулалт жилд дунджаар 73 орчим хувь байгаа аж.¹⁴

«Өвөр Монголын хөдөө аж ахуйн газар зүй» мөн номд бичсэнээс үзэхэд мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, нэг малаас авах ашиг шим зэрэг олон үзүүлэлтийг мал аж ахуй хөгжсөн оронтой харьцуулахад маш доогуур байгаа юм.¹⁵ Энэ бүхэн нь ХКН-аас

11 «Өвөр монголын өдрийн сонин» 1985. 12. 22.

12 «Өвөр монголын өдрийн сонин» 1980 10. 24

13 «Өвөр монголын өдрийн сонин» 1980. 11.08

14 Өвөр монголын өөртөө засах орны тойм байдал Хөх хот, 1984, 73-р тал

15 Нэй Мэнгу нун е дили. Хөх хот. 1982 151—172-р тал

үндэсний өөртөө засах орны мал аж ахуйн талаар 1970-аад онд явуулсан алдаатай бодлогын уршигт үр дагавар болохыг ХКН-ын удирдлага албан ёсоор хүлээн зөвшөөрсөн билээ.

ХКН-ын XI удаагийн Төв Хорооны III бүгд хурлын (1978) шийдвэрийн дагуу 1980 оноос Хятад дахь аж ахуйн системийн шинэтгэлийн хүрээнд ӨМӨЗО-ы мал аж ахуйн үйлдвэрлэлд зохион байгуулалтын талаар зарим өөрчлөлт хийж эхэлсэн юм. Юуны өмнө мал, бэлчээрийг нийт үндэстний өмч болгон тэгшитгэн хуваарилж коммуны өмч байсныг өөрчлөв. Бэлчээрийг дур мэдэн хагалахыг хатуу хориглож, Өвөр Монголд мал аж ахуйг гол салбар болгон хөгжүүлэх үндсэн чиглэл тогтоов. Үүнтэй уялдан мал аж ахуйн үйлдвэрлэлд «үйлдвэрлэлийн хариуцлагын дүрэм» хэрэгжүүлж байна. Энэ дүрэм нь мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй шууд холбогдоно. Үйлдвэрлэлийн хариуцлагын дүрэм олон янзын хэлбэртэй юм. Сүүлийн үед малыг малчидад тараан өгч, нутаг бэлчээрийг тэдэнд гардан хариуцуулдаг давхар хариуцлагын дүрэм хэрэгжүүлж байна. Энэ дүрэм нь үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болох бэлчээр мал хоёрыг шүтэлцээ холбоотойгоор авч үзсэнээрээ урьд өмнөх хариуцлагын дүрмээс нэлээд онцлогтой юм. Хариуцлагын дүрэм ёсоор сум гацааны нутаг бэлчээрийг нарийвчлан хэмжиж хаанаас хаа хүртэл хичнээн хэмжээний нутаг бэлчээрт хэдэн толгой мал малласан, ямар малтай хэнийх гэдэг өрх айл, дугуйлан (хэд, хэдэн өрх айл Ц. Б) эзэмшихийг тогтоож түүнийг урт хугацаагаар ашиглах эрхийн үнэмлэх бичиг олгожээ.

Улсын өмч болох ус, бэлчээр ашиглах энэхүү эрхийн үнэмлэх авсан мал аж ахуйн үйлдвэрлэлийн анхан шатны нэгж өрх айл ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тэнд тодорхой заасан байна. Малчид хариуцсан нутаг бэлчээрт тор татаж хашиж хамгаалах, тэжээлийн урга мал, мод тарих, усалж бордох, хадлан тэжээл авч бэлчээрийг ариг гамтай ашиглах эрх эдлэнэ. Түүнийг дур мэдэн хагалах, хөрсөн доорх баялагийг ухаж ашиглахыг хоригложээ. Түүнчлэн уг нутаг бэлчээр байгаль цаг уурын ямар бүсэд оршиж байгаа болон бэлчээр тэжээлийн нөөц, өвс ургамлын гарц зэргийг харгалзан ус, бэлчээр ашигласны татварыг тогтоосон журмаар улсад тогтмол төлж байх үүрэг хүлээнэ.

Улсын өмч болох малыг малчин өрхөд хариуцуулахдаа ажиллах хүчний олон цөөн, байгаль цаг уурын нөхцөл зэргийг харгалзан маллах малынх нь тоо толгойг тогтооно. Өвөр Монголын төв болон дорнод хэсгийн тал хээрт үхрийг 100 — 200, адууг 300-500, хонийг 800—1000 толгойгоор суурилдаг байхад баруун хэсгийн хээрийн бүсэд үхрийг 50—100, адууг 100 — 200, хонийг 300—500 толгойгоор суурилна.¹⁶ Малыг бод богоор нь ялгаж үндсэн хөрөнгийн данс бүртгэлд авч үнэ тогтоодог байна. Жишээлбэл: Үхэр, адуу 200—250, хонь 20, ямааг 15 юаниар тус тус үнэлж богийг 3 жилээр, бодыг 5 жилээр хариуцан маллах гэрээ байгуулна. Суурьт байгаа хээлтэгч малын тоог нарийн тогтоож, 100 эхээс бойжуулах төлийн хувьд маш хатуу гэрээ тогтооно.

Хариуцлагын дүрэм ёсоор малчид жил бүрийн хавар, намрын улиралд хошуу, сум, гацаанаас өгсөн төлөвлөгөөний дагуу мал, мах, сүү, цагаан идээ, үс ноос зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг тогтоосон хувь хэмжээний дагуу улсад нийлүүлнэ. Үйлдвэр

лэлийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн малчдад үнийн 50 хувийн нэмэгдэл урамшуулал олгоно.

Тухайн жилд улсад мал, мах нийлүүлэх албан журмын ноогдлоос татгалзсан малчин өрхөөс гацааны зөвлөл эрхийнхээ дагуу хариуцуулсан малаа буцааж авна.

Малчид хариуцаж байгаа малаа солих, алдаж үрэгдүүлэх, хээлтэгч малыг ихээр хороосон байвал үнийг нь тэднээр хоёр нугалуулж төлүүлдэг байна. Мал аж ахуйн үйлдвэрлэл явуулахад шаардагдах бүх зардлыг малчин өрх гаргана. Малын хорогдол бага, төлийг тогтоосон хэмжээнээс илүү өсгөсөн бол малчид түүнийг худалдан борлуулах, хувийн хэрэгцээнд ашиглах эрх эдлэнэ. Мал аж ахуй эрхэлж буй нутагт товаарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд дотоод зах зээлийн механизмыг өргөн ашиглаж малчдыг ч түүнд татан оролцуулах болов.

Малчид малын хариулага маллагааны хөлс авахгүй. Зөвхөн мал, мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулалтаас орох орлогоороо цалинжина. Малчид тухайн жилд мал аж ахуйн үйлдвэрлэлээс олсон орлогоо бодуулж тооцоо хийсний дараа сум, гацааны зөвлөлд тогтоосон хувь хэмжээний дагуу ашиг орлогын татвар төлдөг байна. 1979 онд ӨМӨЗО-ы Намын хорооноос баталсан газар тариалан, мал аж ахуйн районд мөрдөх 10 зүйлт дүрмийн VII зүйлд зааснаар мал аж ахуй эрхэлж буй бүс нутгийн өрх айлын хүн тус бүр хувьдаа 10 толгой хонь, ямаа болон үхэр, адуу, тэмээг цөөн тоогоор өсгөхийг зөвшөөрчээ.¹⁷ Үүнийг 1981 оны 2-р сард ӨМӨЗО-ы Ардын засгийн ордноос баталсан «хөдөө, тосгон, мал аж ахуйн районы эдийн засагт явуулах бодлогын асуудлаархи тогтоолын зүйлд бататгаж малчид аминдаа цөөн тооны хонь үхэр, унааны морьтой байхыг зөвшөөрнө гэсэн байна.¹⁸ 1980 оны байдлаар ӨМӨЗО-ы малчдын амины мал 10,9 сая байсан нь бүх мал сүргийн 34 хувийг эзэлж байв. Дээрхи баримт бичгээс үзэхэд малчид аминдаа тогтоосон хэмжээний дагуу цөөн тооны малтай байж болох бөгөөд уг тооноос үлдсэн малаа улсад худалдан борлуулах буюу хувийн хэрэгцээнд хэрэглэх эрхтэй ажээ. Үүнтэй холбогдуулан дурьдахад өмч, өмчийн харилцааны асуудал энд бүрэн шийдвэрлэгдээгүй байна.

Хятадын улс ардын аж ахуйд Өвөр Монголын бэлчээрийн мал аж ахуйн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байгаатай уялдан ХКН-аас сүүлийн үед энэ салбарт явуулж байгаа шинэчлэлтийн бодлого өнөөгийн байдлаар зарим нааштай үр дүнд хүрч байна. Тухайлбал, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ урьд өмнөх үетэй харьцуулбал бага зэрэг нэмэгдэж хариуцлагын дүрэм хэрэгжүүлсэн хугацаанд мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 7 хувь орчим өсчээ.¹⁹

Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт үндсэн арга ажиллагааг эзэмшсэн малчин монголчуудад энэ аж ахуйгаа эрхлэн хөтлөх эрх олгосоноор тэдний урам зориг сэргэж хөдөлмөрийн идэвх нь өрнөж зарим үр дүнд хүрч байгаа талаар хятадын хэвлэлд олонтоо бичиж байна. Мал аж ахуйг эрхлэн хөтлөх уламжлалт арга ажиллагааг сайн эзэмшсэн хөдөлмөрч малчин монголчуудын аж байдалд ч нэлээд өөрчлөлт гарчээ. 1985 оны байдлаар малчдын жилийн дундач орлого

17 «Жэньминь жибао» 1979. 2. 15.

18 «Өвөр монголын өдрийн сонин» 1981 2. 17.

19 «Хүнц» 1984. № 6. 27-р тал

537 юаньд хүрсэн байна.²⁰ Статистикийн мэдээнээс үзвэл 1985 онд Өвөр Монголын мал аж ахуйн салбарт ажиллаж буй нэг малчин жилд дунджаар 2500 орчим юанийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байхад мөн хугацаанд нэг тариачин 795 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.²¹ Малчдын худалдан авах чадвар өсч, ахуй амьдрал нь урьд өмнөх үеийг бодвол нэлээд дээшилжээ. Зарим малчин өрх нар салхины хүчээр эрчим хүч гаргах авсаархан хөдөлгүүр ашиглах болжээ. Зарим чинээлэг амьдралтай малчид гэртээ радиотой болж, телевиз үзэж, ахуйн хэрэглээний зарим цахилгаан хэрэгсэл ашиглаж байна. Мал аж ахуй эрхэлж буй зарим газар 3-4 өрх нэгдэж улсаас зээл авах буюу өөрсдөө мөнгө гаргах, хөдөө аж ахуйн машин, трактор худалдан авч худаг ус гаргаж, хадлан тэжээл бэлтгэж, хашаа хороо хамтран барьж байна. Энэ хэлбэрийг улсаас талархан дэмжиж байна.

ӨМӨЗО-ны Ардын засгийн ордноос мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангаж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийнх нь хэмжээг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулахын тулд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж буй орны туршлагыг сүүлийн үед нэлээд сонирхож байна. 1986 онд Өвөр Монголын мал аж ахуйн мэргэжилтнүүд бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг орнуудаар явж туршлага судалсан байна. Тухайлбал манай оронд ирж бэлчээрийн мал аж ахуй эрхлэн хөтөлж буй арга туршлагатай танилцсан юм. Түүнчлэн мал аж ахуй эрхлэх нутагт зориулсан тогтмол хэвлэлүүдэд БНМАУ-ын болон бусад орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэн хөтөлж буй арга туршлагыг тогтмол нийтлэх болов.

Мал аж ахуйн салбарт өөрчлөлт хийж байгаатай уялдуулан коммун, их бригад, үйлдвэрлэлийн бригадын хэлбэр бодит байдалд нийцэхгүй байна гэж үзээд 1983 оноос түүнийг өөрчилжээ. Үүний дараа мал аж ахуйн салбарт үйлдвэрлэлийн хариуцлагын дүрмийг хэрэгжүүлж, «бэлчээр-мал-ажиллах хүчний» харьцааг шинээр тогтоож илүүдэл мал, ажиллах хүчний асуудлыг өөр нутаг бэлчээрт шилжүүлэх буюу тэнд нь зохицуулж, мал аж ахуйн дагнасан өрх, үйлчлэх өрх, ханган борлуулах өрх, зам тээвэр, өвс хадлан бэлтгэх өрх, малчдын амины хэрэгцээнээс илүү гарсан малыг худалдан борлуулж зуучлах өрх, ахуйн үйлчилгээ хариуцсан өрх гэх зэрэг хэдэн өрх айлыг нэгтгэсэн аж ахуйн анхан шатны нэгжүүдийг орон нутагт байгуулав. Тэдгээр шинэ нэгж нь гацааны зөвлөлийн хяналтын дор ажиллах бөгөөд орлогынхоо зохих хувийг гацааны зөвлөлд тогтоосон хугацаанд тушаадаг байна. Энэ хэлбэр цаашдаа хөгжиж тус тусдаа бие даан ажил үйлчилгээ явуулж чадах хоршооллосон аж ахуйн эхлэл болох юм гэж тэд үзэж байна.

Бэлчээрийн мал аж ахуйг тухайн нутгийн хоёр дахь аж ахуй болгож байсан урьд өмнөх алдаатай бодлогыг залруулж мал аж ахуйн үйлдвэрлэлийн зогсонги байдлыг гэтлэн давж түүний тогтвортой өсөлтийг хангах, малын үүлдэр угсаа, яс чанарыг сайжруулах, «мал бэлчээр-ажиллах хүчний» зохистой харьцааг бүрдүүлэх чиглэлээр сүүлийн үед авч хэрэгжүүлж буй дээрх арга хэмжээнүүд зохих үр дүнгээ өгч байгаа боловч Өвөр монголын мал аж ахуйг улс ардын аж ахуйн тулгуур салбар болгон хөгжүүлэх хятадын нам төрийн бодлогын үндсэн чиглэлийн үүднээс авч үзвэл энд шийдвэрлэвэл зохих тул

20 «Үйлдлэг» сэтгүүл 1985, № 6, 20-р тал

21 Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан» сэтгүүл 1986. № 6, 9-р тал

гамдсан асуудлууд байсаар байна. Тухайлбал мал өсгөх асуудлыг дан ганц малчдын хүчээр бүтэх зүйл мэтээр өрөөсгөл хандаж мал аж ахуйн салбарт төвлөрсөн хөрөнгө оруулах, түүний материаллаг баазыг бэхжүүлэх, түүнтэй холбоотой аж ахуйн бусад салбартай нягт уялдуулах, 300-мал эмнэлгийн шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх зэрэг чухал асуудлуудыг шийдвэрлэх талаар өнөө хир нэгдсэн арга хэмжээ аваагүй учраас малын зүй бусын хорогдол жил бүр дундчаар 5 сая-д хүрч, энэ нь нийт малын 6—8 хувийг эзэлсэн хэвээр байгаа ажээ.²²